БУЛГАН АЙМГИЙН 2025 ОНЫ "ЁС ЗҮЙ, САХИЛГА ХАРИУЦЛАГЫН ҮНЭЛГЭЭНИЙ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ"

№	Үзүүлэлт	Шалгуур үзүүлэлт		Авбал зохих оноо	Оноо [1]	Хувийн жин [2]
1	2	3		4	5	6
1	Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт (ҮХХ)	Үйл ажиллагааны төлөвлөгөөг шалгуур үзүүлэлттэй нийцүүлэн батлалсан эсэх [4]		1	1	10
2		Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчилд өртөх эрсдэлийн үнэлгээ хийсэн эсэх [5]		1	0.668	6.68
3		Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс сэргийлэх, соён гэгээрүүлэх үйл ажиллагааг хэрэгжүүлсэн байдал	Ёс зүйн сургалтыг 2-оос доошгүй удаа батлагдсан агуулгын хүрээнд зохион байгуулсан эсэх [6]	0.5	0.46	4.6
			Соён гэгээрүүлэх нөлөөллийн ажил зохион байгуулсан байдал [7]	0.5	0.468	4.68
			Ёс зүйн нөлөөллийн мэдүүлэг гаргасан байдал [8]	0.5	0.26	2.6
			Ёс зүйн зөрчлийн хариуцлагын бүртгэлийн маягт бөглөсөн байдал [9]	0.5	0.28	2.8
Хэсгийн оноо				**4**	**3.136**	**31.36**
4	Томилох эрх бүхий албан тушаалтны ёс зүйн манлайлал (ЁЗМ)	Ёс зүйн дэд хорооны дүгнэлтийг үндэслэн шийдвэр гаргасан эсэх [10] (**гарсан дүгнэлтийн хувийн жингээр тооцох бөгөөд гомдол ирээгүй бол 1 оноо**)		1	0.888	8.88
5		Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийг хэрэгжүүлсэн үйл ажиллагааны тайлан, зөрчлийн шийдвэрлэлийг цахим хуудсанд байршуулсан байдал [11]		1	0.88	8.8
6		Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагаа, гишүүдийг урамшуулах санхүүгийн эх үүсвэрийг шийдвэрлэсэн байдал [12]		1	0.32	3.2
Хэсгийн оноо				**3**	**2.088**	**20.88**
7	Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагаа	Дэд хорооны бүрэлдэхүүний хөдөлгөөнийг бүртгэсэн байдал [13]		1	0.896	8.96
8		Төрийн албан хаагчаас ирүүлсэн гомдол, мэдээллийг шийдвэрлэсэн байдал [14] (гомдол ирээгүй бол 1 оноо		1	0.896	8.96

		авна. Нийт ирүүлсэн өргөдөл, гомдлын хувийн жингээр тооцно)			
9		Ёс зүйн зөрчлийн бүртгэл, хяналтын дэд систем дэх дүгнэлт, шийдвэрийг бүртгэж, тайлагнасан байдал [15]	1	0.736	7.36
Хэсгийн оноо			**3**	**2.528**	**25.28**
Үнэлгээний нийт оноо, хувь			**10**	**7.752**	**77.52**

БУЛГАН АЙМГИЙН 2025 ОНЫ ЁС ЗҮЙН ДЭД ХОРООНЫ ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ХЭРЭГЖИЛТИЙН "ТАЙЛАНГИЙН МАЯГТ"

НЭГ. Товч танилцуулга

Булган аймгийн хэмжээнд 2025 онд төрийн 118 байгууллагад ёс зүйн дэд хороо ажиллаж, төрийн албан хаагчдыг ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх чиглэлээр 38 удаагийн сургалт, семинар, зөвлөгөөнийг зохион байгуулж, давхардсан тоогоор 149 байгууллагын 3279 төрийн албан хаагчийг хамруулж, нийт төрийн албан хаагчдын 78.8 хувийг эзэлж байна. Үүнд:

Монгол Улсын Төрийн албаны зөвлөл, Ёс зүйн хорооноос зохион байгуулсан хойд бүсийн төрийн байгууллагын дэргэдэх ёс зүйн дэд хороог чадавхжуулах сургалтад 30 байгууллагын дэргэдэх ёс зүйн хорооны дарга, гишүүн 45 албан хаагч оролцож, ёс зүйн зөрчлийг шийдвэрлэх ур чадварт суралцсан.

Мөн Төрийн албаны зөвлөлийн Булган аймаг дахь салбар зөвлөлөөс 2 удаагийн цахим сургалтыг зохион байгуулж, аймгийн 88 байгууллагын 808 ёс зүйн дэд хорооны гишүүд болон төрийн албан хаагчдыг чадавхжуулсан.

Аймгийн Засаг даргын Тамгын газраас Төрийн албан хаагчийн тухай хуулийн чиглэлээрх сургалтыг 3 удаа зохион байгуулж, 45 байгууллагын 411 албан хаагчийг хамруулсан.

Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн сургалтыг Бүрэгхангай, Баяннуур, Дашинчилэн, Рашаант, Гурванбулаг, Могод, Хишиг-Өндөр, Баян-Агт, Сайхан, Хутаг-Өндөр, Тэшиг, Бугат, Сэлэнгэ, Хангал сум, Хялганат тосгоны нийт 32 төрийн байгууллагын 2015 албан хаагчид сургалт, мэдээллийг зохион байгуулж, төрийн албан хаагчдын мэдлэг, ур чадварыг хөгжүүллээ.

Аймгийн хэмжээнд төрийн байгууллага төрийн албан хаагчтай холбоотой 15 гомдол мэдээллийг хүлээн авч, Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн 15 дугаар зүйлийн дагуу байгууллагын ёс зүйн дэд хорооны хурлаар хэлэлцүүлж, холбогдох албан тушаалтнаас тайлбар мэдээлэл авч, дүн шинжилгээ хийж, дүгнэлт гаргах ажлыг зохион байгуулж, гомдол мэдээлэл гаргасан албан тушаалтанд хуулийн хугацаанд мэдэгдэн ажиллалаа.

ХОЁР. Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийн талаар

2.1. Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт: Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөрийн /2024-2030/ Монгол Улсын Их Хурлын 2024 оны 27 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөр", Ёс зүйн хорооны 2024 оны 05 дугаар тогтоолоор батлагдсан "Ёс зүйн дэд хорооны ажиллах журам"-ыг баримтлан төрийн байгууллагын ёс зүйн дэд хороод салбар, байгууллагын түвшинд сургалт, соён гэгээрүүлэх үйл ажиллагааг тогтмол зохион байгууллаа. Аймгийн хэмжээнд жил бүрийн 11 дүгээр сарыг Төрийн албан хаагчийн сар болгон зарлаж, төрийн албан хаагчдад чиглэсэн сургалт, соён гэгээрүүлэх болон олон нийтийн оролцоотой арга хэмжээг зохион байгуулдаг. Энэ онд Аймгийн Засаг даргын 2025 оны А/680 дугаар захирамжаар "Чадварлаг төрийн албан хаагч-Хариуцлагатай төрийн алба" сарын аяныг зарлаж, аяны хүрээнд төрийн байгууллага, төрийн албан хаагчдын ажил мэргэжлийн онцлогийг харуулсан видео контентын уралдаан, Төрийн байгууллагуудын дунд "Талархлын долоо хоног", Соён гэгээрүүлэх сургалт, мэдээлэл, нөлөөллийн арга хэмжээ, "Чадварлаг төрийн албан хаагч-Хариуцлагатай төрийн алба" сэдэвт илтгэлийн уралдаан, "Алтан хонх" хөгжөөнт танин мэдэхүйн тэмцээн, "Зөвлөн тусалж, өвлөн суралцая" уулзалт (Төрийн албаны ахмад, дунд, залуу үеийн албан хаагчдын туршлага солилцох уулзалт), Төрийн албан хаагчдын волейболын аварга шалгаруулах тэмцээнийг тус тус зохион байгуулж, төрийн 124 байгууллагын 3720 төрийн албан хаагч оролцлоо. Тус аяны хүрээнд төрийн байгууллага, төрийн албан хаагчдын ажлын бүтээмж,

хамт олны харилцаа, хандлагад эерэгээр нөлөөлж, ёс зүйн зөрчил, маргаан буурсан эерэг нөлөөллийг нэмэгдүүлсэн.Төрийн байгууллагын хүний нөөцийг хөгжүүлэх, төрийн албан хаагчдын мэдлэг, ур чадвар, ёс зүйг сайжруулах чиглэлээр 2025 онд олон талт арга хэмжээг зохион байгууллаа. Аймгийн хэмжээнд нийт 86 удаагийн дотоод сургалт, зөвлөгөөн, семинарыг зохион байгуулж, давхардсан тоогоор 5375 төрийн албан хаагчийг хамруулаа. Мөн төрийн байгууллагын үйл ажиллагаа, төрийн албан хаагчийн ёс зүй харилцаа хандлагын талаарх иргэдийн санал хүсэлтийг сонсох, төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулахаар "Иргэдийн индэр" уулзалт, шууд нэвтрүүлгийг 14 хоног тутам зохион байгуулж, 11 удаагийн нэвтрүүлгээр 478 иргэний санал хүсэлтийг хүлээн авч шийдвэрлэлээ. Тус ажлын хүрээнд төрийн үйлчилгээг иргэд, олон нийтэд сурталчлан таниулах, иргэдийн санал, хүсэлтийг шийдвэрлэж, бодлого, төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлэх ажлыг зохион байгууллаа.

Аймгийн хэмжээнд 4161 төрийн албан хаагч ажиллаж байгаагаас 5 хүртэл жил ажиллаж буй албан хаагч 1158 буюу 27.8 хувийг эзэлж байна. Шинэ, залуу албан хаагчдыг чадваржуулах, ур чадварыг дээшлүүлэх сургалт, нөлөөллийн арга хэмжээг давхардсан тоогоор **34** удаа зохион байгуулж, давхардсан тоогоор хамрагдвал зохих төрийн албан хаагчдын **87** хувийг хамруулаа.

Төрийн албаны сургалт ба мэдлэг чадвар бий болгох үйл явцад төрийн бус байгууллагуудтай хамтран Төрийн албан хаагчдын ажил, мэргэжил, чиг үүргийн онцлогт тохирсон, мэдлэг, ур чадварыг нэмэгдүүлэхээр 33 төрийн бус байгууллагуудтай хамтран 68 удаагийн сургалт мэдээллийг зохион байгуулж 1700 төрийн албан хаагчийг хамруулсан байна. Төрийн албан хаагчийн манлайлал, Төрийн албан хаагчийн ёс зүй, Байгууллагын алсын хараа эрхэм зорилго үнэт зүйлс, Байгууллагын соёл, Байгууллагын менежментээ сайжруулах нь багийн менежмент, Хууль эрх зүй, ёс зүй, хандлага, дата шинжилгээний ур чадварыг эзэмшүүлэх, оффисын хэрэглээний программын талаар мэдлэг олгох "DATA ANALYSIS- ПРАКТИК" сургалтуудыг тус тус зохион байгуулсан.

2.2. Томилох эрх бүхий албан тушаалтны ёс зүйн манлайлал

Аймгийн нутгийн захиргааны байгууллагуудын удирдах ажилтны шуурхай хуралдааныг 14 хоног тутам зохион байгуулж, холбогдох цаг үеийн мэдээ мэдээллийг хүргэн ажиллалаа. 2025 онд 29 удаа хуралдаж, байгууллагын удирдах албан тушаалтнуудад цаг үеийн шинжтэй мэдээ, мэдээллийг тогтмол танилцуулж, 256 үүрэг чиглэл өгч, хэрэгжилтийг тухай бүр танилцуулж хэвшсэн. Удирдах албан тушаалтнуудад "Улирлын шуурхай зөвлөгөөн"-ийг улирал тутам зохион байгуулж 1, 2, 3 дугаар улирлын зөвлөгөөнд сумд, байгууллагын 90 гаруй удирдлагууд оролцож, Төрийн албан хаагчийн ёс зүй", "Ур чадвар – Манлайлал", Төрийн албан Төрийн албаны тогтолцоо, чиг үүрэг, бодлого төлөвлөлт ба түүний үр нөлөөг сум, орон нутаг, байгууллагын үйл ажиллагаанд тусгах нэгдсэн зорилттойгоор зохион байгууллаа. Мөн төрийн албаны зөвлөл болон Удирдлагын академийн хамтарсан "Төрийн албан хаагчийн ёс зүй" сэдэвт сургалтад аймгийн Засаг даргын тамгын газрын ёс зүйн дэд хорооны дарга Б.Одхүү, гишүүн Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтсийн дарга Ч.Цогбуян, Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн мэргэжилтэн А.Хүслэн нар хамрагдсан.

2.3. Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагаа

Аймгийн Засаг даргын Тамгын газар болон Тамгын газрын харьяа хэвтээ удирдлагын тогтолцоотой байгууллагууд, мөн 16 сум, 1 тосгоны Засаг даргын Тамгын газрын дэргэдэх ёс зүйн дэд хороод нь Төрийн албан хаагчдын хууль, тогтоомж, төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, дүрэм, журмыг мөрдөхөд чиглэсэн соён гэгээрүүлэх 38 удаагийн сургалт, семинар, зөвлөгөөнийг зохион байгуулж, давхардсан тоогоор 149 байгууллагын 3279 төрийн албан хаагчийг хамруулаа. Тайлант хугацаанд 15 гомдол мэдээллийг хүлээн авч, Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн 15 дугаар зүйлийн дагуу байгууллагын ёс зүйн дэд хорооны хурлаар хэлэлцүүлж, холбогдох албан тушаалтнаас тайлбар мэдээлэл авч, дүн шинжилгээ

хийж, дүгнэлт гаргах ажлыг зохион байгуулж, гомдол мэдээлэл гаргасан албан тушаалтанд хуулийн хугацаанд мэдэгдэн ажиллалаа.	
Гарсан үр дүн, ололт амжилт: Сургалт, мэдээллийг тогтмол зохион байгуулснаар төрийн албан хаагчдын хууль, эрх зүйн мэдлэг нэмэгдэж, ёс зүй, харилцаа хандлагад тодорхой өөрчлөлт гарсан. Ажлын байрны эерэг үзүүлэлтүүд нэмэгдэж, ажлын бүтээмжид ахиц гарсан. Төрийн албан хаагчдын багаар ажиллах чадвар нэмэгдсэн.	Бэрхшээл: Ёс зүйн дэд хороод төлөвлөгөөний дагуу сургалт мэдээллийг зохион байгуулах нь ажлын давхардал ачааллыг нэмэгдүүлсэн. Төрийн байгууллагуудын ёс зүйн дэд хорооны урамшууллыг улирал тутам олгоогүй.
Санал:	

Шалгах хэсэг:

- ✓ Ёс зүй, сахилга хариуцлагын үнэлгээний шалгуур үзүүлэлт”-ийн дагуу үнэлгээ хийсэн эсэх.
- ✓ ~~Үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн үр дүнгийн хяналт-шинжилгээ, үнэлгээний~~ шалгуур үзүүлэлтэд нийцүүлэн баталсан үйл ажиллагааны төлөвлөгөө хавсаргасан эсэх.
- ✓ Байгууллагын 2025 оны Ёс зүйн дэд хорооны хууль тогтоомжийн хэрэгжилтийн тайланг маягтын дагуу бүрэн тайлагнасан эсэх.

БАТАЛГААЖУУЛАЛТ:

ТОМИЛОХ ЭРХ БҮХИЙ АЛБАН ТУШААЛТАН
БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА ..... Д.ЭРДЭНЭБИЛЭГ

ЁС ЗҮЙН ДЭД ХОРООНЫ ДАРГА
ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ХЭЛТСИЙН ДАРГА ..... Б.ОДХҮҮ

ЁС ЗҮЙН ДЭД ХОРООНЫ НАРИЙН БИЧГИЙН ДАРГА
ХҮНИЙ НӨӨЦИЙН БОДЛОГО ХАРИУЦСАН
АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН ..... А.САРАНТУЯА

		Үйл ажиллагааны төлөвлөгөөг шалгуур үзүүлэлттэй нийцүүлэн баталсан эсэх	Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчилд өртөх эрсдэлийн үнэлгээ хийсэн эсэх	Ёс зүйн сургалтыг 2-оос доошгүй удаа батлагдсан агуулгын хүрээнд зохион байгуулсан эсэх	Соён гэгээрүүлэх нөлөөллийн ажил зохион байгуулсан байдал	Ёс зүйн нөлөөллийн мэдүүлэг гаргасан байдал	Ёс зүйн зөрчлийн хариуцлагын бүртгэлийн маягт бөглөсөн байдал	Ёс зүйн дэд хорооны дүгнэлтийг үндэслэн шийдвэр гаргасан эсэх [10] **(гарсан дүгнэлтийн хувийн жингээр тооцох бөгөөд гомдол ирээгүй бол 1 оноо)**	Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийг хэрэгжүүлсэн үйл ажиллагааны тайлан, зөрчлийн шийдвэрлэлийг цахим хуудсанд байршуулсан байдал [11]	Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагаа, гишүүдийг урамшуулах санхүүгийн эх үүсвэрийг шийдвэрлэсэн байдал [12]	Дэд хорооны бүрэлдэхүүний хөдөлгөөнийг бүртгэсэн байдал [13]	Төрийн албан хаагчаас ирүүлсэн гомдол, мэдээллийг шийдвэрлэсэн байдал [14] (гомдол ирээгүй бол 1 оноо авна. Нийт ирүүлсэн өргөдөл, гомдлын хувийн жингээр тооцно)	Ёс зүйн зөрчлийн бүртгэл, хяналтын дэд систем дэх дүгнэлт, шийдвэрийг бүртгэж, тайлагнасан байдал [15]
	Авбал зохих оноо	1	1	0.5	0.5	0.5	0.5	1	1	1	1	1	1
	Оноо	1	0.668	0.46	0.468	0.26	0.28	0.888	0.88	0.32	0.896	0.896	0.736
	Хувийн жин [2]	10	6.68	4.6	4.68	2.6	2.8	8.88	8.8	3.2	8.96	8.96	7.36
1	Аймгийн Засаг даргын тамгын газар	1	0.5	0.5	0.5	0.5	0	0.5	0.5	0.5	1	0.5	0.5
2	Байгаль орчны газар	1	1	0.5	0.5	0.5	0	1	1	1	1	1	1
3	Орон нутгийн өмчийн газар	1	1	0.5	0.5	0.5	0.5	0.7	1	0	0.9	0.9	0.9
4	Санхүүгийн хяналт, аудитын алба	1	1	0	0.5	0	0.5	1	1	0	1	1	1
5	Хүнс, хөдөө аж ахуйн газар	1	0.5	0.5	0.5	0.5	0.5	0	1	0	1	1	1
6	Эрүүл мэндийн газар	1	0.5	0.5	0.2	0	0	1	1	0	0	1	0
7	Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар	1	1	0.5	0.5	0.5	0	1	1	1	1	1	1
8	Худалдан авах ажиллагааны газар	1	0.5	0.5	0.5	0	0	1	1	0	0	1	1
9	Баян-Агт сумын Засаг даргын тамгын газар	1	1	0.5	0.5	0	0	1	1	1	1	1	0
10	Баяннуур сумын Засаг даргын тамгын газар	1	1	0.5	0.5	0.5	0	1	1	0.5	1	1	0.5
11	Бугат сумын Засаг даргын тамгын газар	1	0.5	0.5	0.5	0.5	0.5	1	0.5	1	1	1	0.5
12	Булган сумын Засаг даргын тамгын газар	1	0.5	0.5	0.5	0.5	0.5	1	1	1	1	1	1
13	Бүрэгхангай сумын Засаг даргын тамгын газар	1	1	0.5	0.5	0	0.5	1	1	0	1	1	0
14	Гурванбулаг сумын Засаг даргын тамгын газар	1	0.5	0.5	0.5	0	0.5	1	1	0	1	0	0
15	Дашинчилэн сумын Засаг даргын тамгын газар	1	0.2	0.5	0.5	0	0.5	1	1	0	1	1	1
16	Могод сумын Засаг даргын тамгын газар	1	1	0.5	0.5	0	0	1	1	1	0.5	1	1
17	Орхон сумын Засаг даргын тамгын газар	1	1	0.5	0.5	0	0	1	1	0	1	1	1
18	Рашаант сумын Засаг даргын тамгын газар	1	1	0.5	0.5	0.5	0.5	1	1	0	1	1	1
19	Сайхан сумын Засаг даргын тамгын газар	1	1	0.5	0.5	0.5	0.5	1	1	1	1	1	1
20	Сэлэнгэ сумын Засаг даргын тамгын газар	1	0	0.5	0.5	0	0	1	1	0	1	1	1
21	Тэшиг сумын Засаг даргын тамгын газар	1	1	0.5	0.5	0.5	1	1	1	0	1	1	1
22	Хангал сумын Засаг даргын тамгын газар	1	0	0.5	0.5	0.5	0.5	1	0	0	1	1	1
23	Хишиг-Өндөр сумын Засаг даргын тамгын газар	1	1	0.5	0.5	0.5	0.5	1	0	0	1	1	1
24	Хүтаг-Өндөр сумын Засаг даргын тамгын газар	1	0	0.5	0	0	0	1	1	0	1	0	1
25	Хялганат тосгоны захирагчийн алба	1	0	0	0.5	0	0	0	1	0	1	1	0